

**2002 ОНД МОНГОЛ УЛС ГАДААДТАЙ ХАРИЛЦСАН ГОЛ
ҮЙЛ ЯВДЛЫН ЖАГСААЛТ***У.Загдцэсэм*

01. 07-12 Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Жу Рунжигийн урилгаар БНХАУ-д албан ёсны айлчлал хийв. Айлчлалын үеэр Монгол улсын Ерөнхий сайд БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Жу Рунжитэй албан ёсны хэлэлцээ хийж, БНХАУ-ын дарга Зян Зэминь, БХАТИХ-ын Байнгын хорооны дарга Ли Пэн нарт бараалхав. Хоёр тал байгалийн баялагийг нээн ашиглах, Монгол Улсын "Мянганы зам" төслийг хэрэгжүүлэх, Монгол Улсын зүүн бүсийг Хятадын зүүн хойт бүсийн дэд бүтэцтэй холбох зэрэг томоохон төслүүд дээр хамтран ажиллах талаар санал солилцож, цаашид үргэлжлүүлэн гүнзгийрүүлэн хэлэлцэхээр болов.
01. 08. Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсаас Монгол Улсад суух Онц бөгөөд бүрэн Эрхт Элчин сайд Филип Теренс Рөүз Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандид Итгэмжлэх жуух бичгээ барив.
01. 14. Япон Улсын Засгийн газраас 2002 оны санхүүгийн жилд Монгол Улсад 1 тэрбум 200 сая иенийн үнийн дүн бүхий төслийн бус буцалтгүй тусламж олгох тухай ноот бичигт Монгол Улсын Гадаад Хэргийн сайд Л.Эрдэнэчулуун, Япон Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн Эрхт Элчин сайд М.Ханада нар гарын үсэг зурав. Япон Улсын Засгийн газар манай улсад өнөөг хүртэл 1991-1994, 1996-1999 онуудад бүгд 8 удаа нийт үнийн дүнгээр 14 тэрбум 300 сая иенийн төслийн бус буцалтгүй тусламжийг олгоод байгаа юм.
- 01.16. Узбек Улсаас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Эргашев Иснатуллу Раймович Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандид Итгэмжлэх жуух бичгээ барив.
- 01.30. Ерөнхий сайд Н.Энхбаяр дэлхийн эдийн засгийн дээд хэмжээний чуулга уулзалтад оролцов. Тэрээр "Төв Азийн ирээдүйн төлөв байдал" сэдэвт ярилцалтад тэргүүлэх хэлэлцүүлэгчээр оролцов. Дэлхийн нэр нөлөө бүхий 20 улс орны төр, засгийн тэргүүн, сангийн сайд нар болон төв банкны захирлууд энэхүү уулзалтад оролцож, дэлхийн эдийн

- засгийн өмнө тулгараад байгаа бэрхшээл сорилтууд, тэдгээрийг даван туулах арга замын талаар санал солилцов.
02. 01. Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга М.Дагва, АНУ-аас манай улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Жон Дингер нар АНУ-аас манай иргэний нисэхийн салбарт үзүүлэх техникийн туслалцааны төслийг хэрэгжүүлэх тухай гэрээнд гарын үсэг зурав.
02. 02. Монгол Улсын Санхүү эдийн засгийн сайд Ч.Улаан, Азийн Хөгжлийн Банк /АХБ/-ны ерөнхийлөгч Тадао Чино нар АХБ-аас Монгол улсад олгох Орон сууцны санхүүжилт, Хөдөөгийн санхүүжилтийн төслүүдийн зээлийн хэлэлцээрт Манил хотноо гарын үсэг зурав.
- 02.04-07. Монгол Улсын УИХ-ын дарга С.Төмөр-Очир тэргүүтэй төлөөлөгчид ОХУ-ын Төрийн Думын дарга Г.Н.Селезнёвтай уулзаж Монгол дахь ОХУ-ын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, шинэ хамтарсан үйлдвэр, аж ахуйн нэгжийг байгуулах, худалдааны татварыг либеральчлахыг дахин эргэж харах, соёл, боловсрол, шинжлэх ухаан хүмүүнлэгийн салбарт хамтын ажиллагааг улам өргөжүүлэх зэрэг зарчмын хэд хэдэн асуудал дээр санал нэгдэв.
02. 08. Монгол Улсаас Бүгд Найрамдах ардчилсан Социалист Шри Ланка Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд О.Нямдаваа БНАСШЛУ-ын Ерөнхийлөгч хатагтай Чандрика Бандаранайке Кумаратунга-д Итгэмжлэх жуух бичгээ барив.
02. 12. БНФУ-ын засгийн газраас үзүүлэх Хүнсний тусламжийн хэлэлцээрт Франц Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Ж.О.Манан, Монгол Улсын Гадаад Хэргийн сайд Л.Эрдэнэчулуун нар гарын үсэг зурав. Монгол Улсын Хүнсний аюулгүй байдлын хөтөлбөрийг дэмжих зорилт бүхий Францийн тусламж нь 2003, 2004 онуудад үргэлжлэх юм.
- 02.16. УИХ-ын дарга С.Төмөр-Очир Япон Улсад албан ёсны айлчлал хийх хугацаандаа Японы парламентын зөвлөхүүдийн танхимын дарга Ю.Иноүэ, төлөөлөгчдын танхимын дарга Т.Ватанүки, Япон Улсын Ерөнхий сайд Ж.Койзүми, Япон Улсын Цог Жавхлант Эзэн хаан Акихито, Япон Улсын эрхэм дээд Ханхүү Акишинономия Японы боловсрол, шинжлэх ухааны сайд А.Тояма болон албаны бусад хүмүүстэй уулзаж ярилцав.

02. 19 Бүгд Найрамдах Болгар Улсаас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Николай Марин Монгол Улсын ерөнхийлөгч Н.Багабандид Итгэмжлэх жуух бичгээ барив.
- 02.21. Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандид Бүгд Найрамдах Чили улсаас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн Эрхт элчин сайд Фернандо Шмидт Итгэмжлэх жуух бичгээ барив.
02. 22. “Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай” Монгол Улсын Засгийн газар, Япон улсын засгийн газар хоорондын Хэлэлцээрийг баталсан тухай Ноот, мөн Япон улсын Засгийн газрын Соёлын буцалтгүй тусламжийн хүрээнд Монгол улсын АУИС-д үзэх, сонсох болон хэвлэлийн тоног төхөөрөмж нийлүүлэх тухай Ноот бичигт Монгол улсын Гадаад Хэргийн сайд Л.Эрдэнэчулуун, Япон улсаас Монгол улсад суугаа Онц бөгөөд бүрэн Эрхт Элчин сайд М.Ханада нар гарын үсэг зурав.
02. 26 Бүгд Найрамдах Ардчилсан Алжир Ард Улсаас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд эрхэмсэг ноён Маджид Бугерра Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандид Итгэмжлэх жуух бичгээ барив.
- 02.28-13.05. УИХ-ын дарга С.Төмөр-Очир тэргүүтэй төлөөлөгчид БНТурк улсад ажлын айлчлал хийв. Айлчлалын үеэр Туркийн Үндэсний Их хурлын дарга Ө.Изгичтэй уулзаж хоёр улсын парламент хоорондын хамтын ажиллагааны протоколд гарын үсэг зурав. УИХ-ын дарга С.Төмөр-Очир Турк Улсын Ерөнхийлөгч А.Н.Сээрт бараалхав. Ерөнхийлөгч А.Н.Сэээр 2 улсын засгийн газар хоорондын 20 гаруй гэрээ, хэлэлцээр нь худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны үндэс болж байгааг тэмдэглээд Монгол улсын Батлан хамгаалахын сайдын тус оронд айлчлах үеэрээ байгуулсан цэргийн салбарт хамтран ажиллах протокол чухал ач холбогдолтой болохыг онцлон тэмдэглэв.
- 03.01. Монгол Хятадын Засгийн газар хооронд 2001 оны 7-р сарын 2, 2002 оны 1-р сарын 7-нд тус тус байгуулсан Эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны гэрээнүүдийн хүрээнд Хятадын Засгийн газраас Монгол Улсад олгож байгаа 45 сая юаны буцалтгүй тусламжийг орон сууц болон эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны төслүүдийг санхүүжүүлэх, 50 сая юаны буцалтгүй тусламжийг хамтын ажиллагааны төсөл, өргөн хэрэглээний бараа авахад зориулж олгохоор шийдвэрлэв. Энэхүү буцалтгүй тусламжийн санхүүжилт,

- төлбөр тооцоог Хятад Банк Монгол Банкаар дамжуулан хийх хэлэлцээрт Монгол Банкны Ерөнхийлөгч О.Чулуунбат, БНХАУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Хуан Жакуй нар гарын үсэг зурав.
- 03.02. Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр АНУ-аас Монгол улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Жон Дингерийг хүлээн авч уулзав.
- 03.06. Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр Бүгд Найрамдах Болгар Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд ноён Николай Мариныг хүлээн авч уулзав. Монгол Болгарын Засгийн газар хоорондын хуралдааныг энэ онд Софи хотноо зохион байгуулах, Баянхонгор аймаг дахь Монгол, Болгарын хамтарсан алт олборлох аж ахуйн нэгжийг хувьчлах, 2 талын өрийн асуудлыг шийдвэрлэх, батлан хамгаалах салбарт хамтын ажиллагаагаа сэргээх зэрэг асуудлуудаар саналаа илэрхийлэв.
- 03.08. Нидерландын Вант Улсын сангийн сайд, ноён Геррит Залли Монгол Улсад ажлын айлчлал хийв. Айлчлалын үеэр “Орлогын татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай” Монгол Улсын Засгийн газар, Нидерландын Вант Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрт гарын үсэг зурав.
- 03.16. УИХ-ын дарга С.Төмөр-Очир ХБНГУ-аас Монгол улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Клаус Шрёдерийг хүлээн авч уулзав. Уулзалтын үеэр боловсролын салбарт хамтран ажиллах асуудал түүний дотор хөдөөгийн сургуулиудын материаллаг баазыг бэхжүүлэх, Улаанбаатар хот дахь Монгол-Германы хамтарсан сургуулийн үйл ажиллагаа болон Боловсролын сайд байхдаа энэ салбарт ХБНГУ-ын Бавари мужтай тогтоосон харилцаа, энэ хүрээнд байгуулсан Герман-Монголын Мэдээллийн төвийн үйл ажиллагааг сэргээх зэрэг асуудлаар санал солилцов.
- 03.20. Монгол Улсын ерөнхий сайд Н.Энхбаяр АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн эдийн засгийн бодлогыг дэмжих төслийн захирал, ноён Харри Бауманныг хүлээн авч уулзан эдийн засгийн өсөлтийг хангах, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, малчдыг эдийн засгийн харилцаанд татан оруулах, татварын болон төсвийн зардлыг шинэчлэлийг хийх зэрэг өргөн хүрээний асуудлуудаар санал солилцов.

03. 25-26 Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаярын урилгаар ОХУ-ын Засгийн газрын дарга М.М.Касьянов Монгол Улсад албан ёсны айлчлал хийв. Айлчлалын үеэр Монгол Улс, ОХУ-ын хоорондын Консулын конвенц, Худагдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны засгийн газар хоорондын 2002 оны Протокол, Монгол Улсын ЭМЯ, ОХУ-ын ЭМЯ хооронд Эрүүл мэнд, анагаах ухааны салбарт 2002-2004 онд хамтран ажиллах Протокол, Монголын биеийн тамир, спортын Үндэсний хороо, ОХУ-ын Биеийн тамир, спорт, аялал жуулчлалын Улсын хорооны хооронд Биеийн тамир, спортын талаар хамтран ажиллах тухай Хэлэлцээр, Монгол улсаас ОХУ-д 2001-2002 онд төлөх урсгал өрийг зохицуулах асуудлаар хийсэн хэлэлцээний Протокол, Шатдаг хийн салбарт хамтран ажиллах тогтвортой байдлын Гэрээ, Монгол Улсын ҮХЯ, БН Алтай улсын төлөөлөгчдийн ажлын уулзалтын санамж бичиг зэрэгт гарын үсэг зурж, Монгол-Оросын хил шалгасан дүнгийн тухай ноот бичгийг солилцов.
03. 27-29 Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж БНСУ-д айлчлав. Тэрээр БНСУ-ын Хууль зүйн сайд Сон Жөн Хо, Дээд шүүхийн ерөнхий шүүгч Чвэ Жон Ен, Ерөнхий прокурор И Мен Жэ, Засгийн газрын дэргэдэх хууль тогтоомжийн удирдах газрын дарга Пак Чан Жү нартай уулзаж хоёр улсын хооронд иргэдийн асуудлаар байгуулсан гэрээ хэлэлцээрүүдийн хэрэгжилтийг хангах, хууль хяналтын байгууллагуудын хооронд цогц харилцаа тогтоон цагдаа, засан хүмүүжүүлэх, хилийн шалган нэвтрүүлэх зэрэг албадын шууд хамтын ажиллагааг өргөжүүлэх, Монголд хэрэгжүүлж буй хуулийн шинэчлэлийг төгөлдөржүүлэх, Монголын хуульчдыг мэргэжлийн сургалтад хамруулах зэрэг өргөн хүрээтэй асуудал хэлэлцэж тохиролцов.
03. 29. “Агаарын харилцааны тухай хэлэлцээр”-т нэмэлт өөрчлөлт оруулах тухай болон “Гал түймэртэй тэмцэх байгууллагын тоног төхөөрөмжийг сайжруулах” төслийг хэрэгжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хооронд солилцох ноот бичигт Монгол Улсын Гадаад Хэргийн сайд Л.Эрдэнэчулуун, Япон Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн Эрхт Элчин сайд М.Ханада нар гарын үсэг зурав. Энэхүү нэмэлт өөрчлөлтийн дагуу энэ оны 4-р сарын 22-нд Улаанбаатар-Токиогийн чиглэлийн анхны нислэг хийгдсэн. Япон Улсын Засгийн газрын буцалтгүй

- тусламжийн хүрээнд манай улсын Гал түймэртэй тэмцэх газарт 739 сая иенийн тусламж үзүүлэх юм.
- 04.09. Словакийн өргөмжлөлт консулын газрыг Улаанбаатар хотноо нээв.
- 04.11. Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандил Бүгд Найрамдах Хорват Улсаас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд З.Киричич Итгэмжлэх жуух бичгээ барив.
- 04.16. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга Р.Болд Турк, ОХУ-ын үндэсний Аюулгүй байдлын зөвлөлийн урилгаар айлчлав.
- 04.16. УИХ-ын дарга С.Төмөр-Очир тэргүүтэй төлөөлөгчид Бээжин хотноо болсон Энх тайвны төлөөх Азийн парламентуудын нийгэмлэгийн гуравдугаар хуралдаанд оролцов.
04. 22-26. ХБНГУ-ын Холбооны канцлер Г.Шрёдерийн урилгаар Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр ХБНГУ-д айлчлав. Айлчлалын үеэр Холбооны канцлер Г.Шрёдер болон албаны бусад хүмүүстэй уулзав. Хессен муж улсын нийслэл Вийсбаден хотод тус мужийн Ерөнхий сайд роланд Кохтай уулзан хамтын ажиллагааг хөгжүүлэх асуудлаар ярилцаж, хамтарсан мэдэгдэлд гарын үсэг зурав. Айлчлалын үеэр Монгол Улсын БСШУ-ы сайд Э.Булмаан нар хамтарсан протоколд гарын үсэг зурав.
04. 23 Монгол Улсаас Бүгд Найрамдах Беларусь Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд С.Баяр Беларусийн Ерөнхийлөгч А.Г.Лукашенкод Итгэмжлэх жуух бичгээ барив.
- 5-р сард. Үйлдвэр худалдааны сайд Ч.Ганзориг тэргүүтэй төлөөлөгчид ОХУ-д ажлын айлчлал хийх үеэр хоёр орны харилцааны эрх зүйн үндсийг цаашид боловсронгуй болгох, ОХУ-д Монголоос нийлүүлэх хүнсний махны хэмжээг нэмэгдүүлж жилд 30 мянган тонн-д хүргэх, монгол малыг эрүүлжүүлэх хамтарсан хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх, Монголд шатдаг хий боловсруулах үйлдвэр байгуулах, Оросын сансрын хиймэл дагуулыг монголын тал ашиглах боломжийг судлах, ОХУ-ын зардлаар сурацах монгол оюутны тоог нэмэгдүүлэх зэрэг асуудлаар дэлгэрэнгүй санал солилцов.
05. 10. Энэтхэгийн Ченнай хотод Монголын Өргөмжит консулын газар нээгдэж үйл ажиллагаагаа эхлэв.
- 05.10-16. Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандийн урилгаар их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Цог

- Жавхлант Хатан хаан II Элизабетийн гэр бүлийн гишүүн, Кентийн гүн Эдвард Монгол улсад айлчлав.
05. 14. Монгол Улсаас БНСВУ-д суугаа Элчин сайд А.Цолмон БНСВУ-ын Гадаад хэргийн дэд сайд Ле Ван Банг нар “Монгол улс, БНСВУ-ын хоорондын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ”, “Монгол улс, БНСВУ-ын хооронд иргэн, гэр бүлийн болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ”-ний Батламж жуух бичгүүдийг солилцсон тухай Протоколд Ханой хотноо гарын үсэг зурав.
05. 14. Монгол Улсаас Данийн Вант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд С.Онон Данийн Цог жавхлант Хатан хаан Маргрете II-т Итгэмжлэх жуух бичгээ барилаа.
05. 16-17. Монгол-АНУ-ын хоёр талын улс төрийн зөвлөлдөх уулзалт Брунейн Даруссаламд болов. Уулзалтад Монголын талаас ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ганболд, Америкийн талаас Зүүн Ази, Номхон далайн асуудал эрхэлсэн төрийн туслах нарийн бичгийн дарга Жэймс Келли нар оролцов. АСЕАН-ы Бүсийн Чуулганы Ахлах түшмэдүүдийн уулзалтын үеэр хоёр талын зөвлөлдөх уулзалтыг сүүлийн жилүүдэд уламжлал болгон зохион байгуулж ирсэн бөгөөд энэ жил дөрөв дэх уулзалт болов.
- 5-р сард. Монгол Улсаас Кувейт Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ч.Болд Кувейтийн Эмир Жабер Аль-Ахмед Аль-Жабер Аль-Сабахт Итгэмжлэх жуух бичгээ барив.
- 05.17. Дэлхийн Банкны Ерөнхийлөгч ноён Жеймс Д.Вольфенсон манай оронд айлчлав. Манай улс Дэлхийн Банкнаас 140-өөд сая долларын өртөгтэй 8 төсөл хэрэгжүүлсэн. Одоо 100 орчим сая долларын 6 төсөл хэрэгжүүлж байна.
05. 24. Монгол Улсаас Малайз Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Л.Даваагив Малайз улсын Цог Жавхлант Хаан Туанку Сайд Путра Жамалулайл-д Итгэмжлэх жуух бичгээ барив.
- 05.25. АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагын урилгаар Хуульзүй дотоод хэргийн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Ц.Нямдорж тэргүүтэй төлөөлөгчид Америкт сургалт айлчлал хийв.
05. 29. Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Канад Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрт Монгол Улсын Засгийн

газрыг төлөөлж Үйлдвэр худалдааны сайд Ч.Ганзориг, Канад Улсын Засгийн газрыг төлөөлж Канадын Олон улсын худалдааны сайд Пьер Петигрю нар Канадын нийслэл Оттава хотноо гарын үсэг зурав.

05. 30. Монгол Улсаас Финлянд Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд С.Баяр Финлянд улсын Ерөнхийлөгч хатагтай Тарья Халоненд Итгэмжлэх жуух бичгээ өргөн барив. Энэ үеэр Монгол, Финляндын харилцаа, хамтын ажиллагааг шинэ нөхцөл байдалд хөгжүүлэхдээ монголын тал давын өмнө байгаль орчноо хамгаалах, ойг нөхөн сэргээх, олон улсын энхийг сахиулах хүчний салбар дахь Финляндын туршлагаас суралцах, хамтран ажиллах, финляндын талын зардлаар монгол оюутан залуучуудыг сургах сонирхолтой байгааг Элчин сайд С.Баяр тэмдэглэв.

06. 01. Бүгд Найрамдах Турк Улсын Ерөнхийлөгч Ахмед Нэждэт Сэээр Монгол Улсын Ерөнхийлөгч Нацагийн Багабандийн урилгаар ажлын айлчлал хийв. Айлчлалын үеэр Монгол-Туркийн худалдаа, эдийн засгийн харилцааг хөгжүүлэхэд ач холбогдолтой “Олон улсын авто тээврийн харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, БНТУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т гарын үсэг зурав.

06. 03-05. Азид хамтран ажиллах, итгэлцлийг бэхжүүлэх Зөвлөлгөөн (АХАИБЗ)-ий Дээд хэмжээний анхдугаар уулзалт БНКазахстан Улсын Алмата хотноо болов. АХАИБЗ-нд 16 улс (Азербайжан, Афганистан, БНХАУ, Египет, Энэтхэг, Иран, Израиль, Казахстан, Киргиз, Монгол, Пакистан, Палестин, ОХУ, Тажикстан, Турк, Узбекистан) гишүүнээр, 9 орон (АНУ, Вьетнам, Индонези, Малайз, БНСУ, Тайланд, Украйн, Япон) ажиглагч улсаар, олон улсын 4 байгууллага (НҮБ, ЕАБХАБ, Арабын улсуудын холбоо болон Европ, Азийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага) ажиглагчийн статустай байна. Энэ дээд хэмжээний анхны уулзалтад Монгол улсын Ерөнхийлөгч Н.Багабанди оролцож, уг хэлэв. Дээд хэмжээний уулзалтад оролцогчид “Алматын Акт”-ад гарын үсэг зурав. Мөн “Иргэншил хооронд яриа хэлцэл өрнүүлэх, терроризмыг үндсээр нь устгах тухай Тунхаглал”-ыг уг уулзалтаас гаргав.

06. 06. Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандид Япон Улсаас Монгол улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Тода Тацуо Итгэмжлэх жуух бичгээ барив.

06. 07. Монгол Улсын ерөнхийлөгч Н.Багабандид Бүгд Найрамдах Киргиз улсаас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Эрлан Б.Абдылдаев Итгэмжлэх жуух бичгээ барив.
06. 19. Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандийн урилгаар Япон Улсын эрхэм дээд хан хүү Акишинономия гэргийн хамт айлчлав.
06. 25. Хууль зүй дотоод хэргийн сайд Ц.Нямдоржийн урилгаар ОХУ-ын Дотоод хэргийн сайд В.Б.Грызлов ажлын айлчлал хийв. Айлчлалын үеэр хоёр тал яам хоорондын 2003 оны хамтын ажиллагааны протоколд гарын үсэг зурав.
06. 27. БНХАУ-ын Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны сайд Ши Гуаншань, Үйлдвэр худалдааны сайд Ч.Ганзориг нар манай улсад 10 сая юаны буцалтгүй тусламж олгох тухай эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны гэрээ, хятад улсад төлөх өрийг хойшлуулах тухай солилцох захидалд гарын үсэг зурав. 1958, 1963 онд БНХАУ-аас авсан 28,9 сая шилжих рубльтэй тэнцэх өрийн төлөгдөх хугацааг 10 жилээр хойшлуулах асуудлыг 2 тал шийдэв.
- 06.30-07.03. Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди Украин Улсын Ерөнхийлөгч Л.Д.Кучмагийн урилгаар Украин Улсад албан ёсоор айлчлав. Хэлэлцээний дүнд талууд Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулан ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Монгол улсын Засгийн газар, Украин улсын Сайд нарын Танхим хоорондын Хэлэлцээр, Монгол улсын БСШУЯ, Украины БШУЯ-ны хооронд 2002-2005 онд хамтран ажиллах тухай Хэлэлцээр, Иргэний ба эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай Монгол улс, Украин улсын хоорондын Гэрээний батламж бичгийг солилцсон тухай Протоколд тус тус гарын үсэг зурав.
- 07.08. Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандид Мьянмарын Холбооны улсаас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд У Сейн Винг Аунг Итгэмжлэх жуух бичгээ барив.
- 07.19-20. Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандийн урилгаар Бүгд Найрамдах Киргиз Улсын Ерөнхийлөгч А.Акаев Монгол улсад албан ёсны айлчлал хийв. Айлчлалын үеэр "Хамтарсан тунхаглал"-д гарын үсэг зурав.

- 07.22-27. Монгол Улсын Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун Япон Улсын Засгийн газрын урилгаар Япон улсад албан ёсны айлчлал хийв.
- 07.24-27. ЮНЕСКО-гийн Ерөнхий захирал К.Мацура Монгол улсад Албан ёсны айлчлал хийв. Айлчлалын үеэр ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комиссын дарга, БСШУ-ны сайд А.Цанжид, ЮНЕСКО-гийн захирал К.Мацура нар Монгол улсын Засгийн газар, ЮНЕСКО-гийн хооронд харилцан ойлголцох санамж бичигт гарын үсэг зурав.
- 07.25-08.01. ХБНГУ-ын Холбооны Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны парламентын төрийн нарийн бичгийн дарга У.Айд Монгол улсад айлчлав. Айлчлалын үеэр Монгол, Германы Засгийн газрын хөгжлийн бодлогын хүрээн дэх эрх зүйн салбарын хамтын ажиллагаа амжилттай хэрэгжиж байгааг харгалзан 1 сая Еврогийн буцалтгүй тусламжийг нэмж олгох болсныг хатагтай У.Айд мэдэгдэв.
- 07.26-29. ОХУ-ын Холбооны Хурлын Холбооны зөвлөлийн дарга С.Миронов Монгол улсад айлчлав. Айлчлалын үеэр УИХ-ын дарга С.Төмөр-Очир, ОХУ-ын Холбооны зөвлөлийн дарга С.Миронов нар 2 орны эдийн засгийн хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурав.
- 07.30-31. Брунейд болсон АРФ-ын сайд нарын 9-р уулзалтад Гадаад хэргийн сайд тэргүүтэй төлөөлөгчид оролцов. Уулзалтаас бүс нутгийн улс төр, аюулгүй байдлыг үнэлж дүгнэсэн даргын мэдэгдэл гарсан бөгөөд манай төлөөлөгчид тус мэдэгдэлд Монгол улс болон түүний цөмийн зэвсэггүй статусын талаар НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн байнгын 5 гишүүн орноос гаргасан хамтарсан мэдэгдлийг сайд нар дэмжиж байгаа тухай заалтыг тусгуулав.
- 08.01-04. Малайзад болсон Панкавийн олон улсын уулзалтад Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаярын бие төлөөлөгчөөр Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун оролцов.
- 08.05-09. Австри улсын Үндэсний Хурлын дарга Хайнц Фишер тэргүүтэй төлөөлөгчид Монгол улсад албан ёсоор айлчлав.
- 08.06-08. Монгол Улсын Гадаад хэргийн сайдын урилгаар НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын Гүйцэтгэх нарийн бичгийн дарга Ким Хаксу Монгол улсад айлчлав.
- 08.07-09. БНАСАУ-ын Гадаад хэргийн сайд Пэк Нам Сүний Монгол Улсад ажлын айлчлал хийв. Айлчлалын үеэр Монгол улс, БНАСАУ-ын хоорондын "Найрсаг харилцаа, хамтын

ажиллагааны тухай Гэрээ”, “Монгол улс, БНАСАУ-ын хооронд байгуулсан гэрээ, хэлэлцээрийн үйлчлэлийн талаарх Монгол улсын Засгийн газар, БНАСАУ-ын Засгийн газар хоорондын протокол”-ыг байгуулав.

- 08.07-13. Монгол улсад байгаа ОХУ-ын үл хөдлөх хөрөнгийн асуудлаар ОХУ-ын Ерөнхийлөгчийн Хэрэг эрхлэх газрын мэргэжилтнүүд Улаанбаатар хотод ирж, Монгол дахь ОХУ-ын зарим барилга байгууламжийг Монголын талд шилжүүлэх нөхцөл, Монгол улс дахь оросын цагаач иргэдэд орон суудыг нь хувьчлах, Чойбалсан хот дахь ОХУ-ын Ерөнхий консулын барилгыг түрээслэх асуудлаар хэлэлцээ хийн, санамж бичигт гарын үсэг зурав.
- 08.09-13. Швейцарийн ГХЯ-ны Хөгжил ба хамтын ажиллагааны албаны дарга Вальтер Фуст, албаны Азийн хэлтсийн дарга Паул Эггер нар Монгол улсад айлчлав. Говь-Алтай аймгийн сумдын 10 жилийн сургуулийн дотуур байранд зориулан 200,000 ам. долларыг нэмж олгох болсноо ноён Фуст албан ёсоор мэдэгдэв.
- 08.16. Япон Улсын Засгийн газрын Хөгжлийн албан ёсны тусламжийн хүрээнд хэрэгжиж буй “Монгол улсын хүний нөөцийг хөгжүүлэх тэтгэлэг” төслийн 2 дахь үе шатыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Монгол Улсын Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун, Япон Улсаас тус улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Т.Тода нар Ноот бичиг солилцов. Энэ үе шатанд зориулан Япон улсын засгийн газар 297 сая иен олгохоор шийдвэрлэсэн байна.
- 08.16-19. Монгол Улсын Гадаад хэргийн сайдын урилгаар БНАЛАУ-ын Ерөнхий сайдын орлогч, Гадаад хэргийн сайд Сомсават Ленгсават Монгол Улсад албан ёсоор айлчлав. Гадаад хэргийн сайд нар хэлэлцээ хийж, хоёр талын харилцааг цаашид эрүүл мэнд, боловсрол зэрэг боломжтой салбаруудад хөгжүүлэх, хувийн хэвшлийн шугамаар харилцаа холбоо тогтоож, хамтын ажиллагаа хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, Гадаад хэргийн яамд хоорондын хамтын ажиллагааг идэвхжүүлэх, далайд гаригүй орнуудын хувьд НҮБ-ын хүрээнд хамтран ажиллах талаар санал солилцож дипломат харилцаа тогтоосны 40 жилийн ойг тэмдэглэх хүрээнд харилцан зохиох арга хэмжээг тохирлоо.
- 08.21-25. Бүгд Найрамдах Казахстан Улсын Мажилисийн орлогч дарга М.Ж.Копей тэргүүтэй төлөөлөгчид манай оронд айлчлав.

- 09.06-19. Монгол Улсын Ерөнхий сайдын ХБНГУ-д хийсэн айлчлалын мөрөөр Хессен муж улстай газар болон үл хөдлөх хөрөнгийн кадастериин салбарт хамтран ажиллах чиглэлийг тогтоох зорилгоор төлөөлөгчид Монголд ирж семинар зохион байгуулав.
- 09.08-12. БСШУ-ны сайд А.Цанжид ОХУ-д албан ёсны айлчлал хийв. Айлчлалын үеэр ОХУ-ын Боловсролын сайдтай уулзан хэлэлцээ хийж, ОХУ-ын төрөл бүрийн мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэдэг их дээд сургуулиудад монгол охид хөвгүүдийг суралцуулах, мэргэжилтнүүдийг давтан бэлтгэх, багш эрдэмтдийг харилцан айлчлуулах, Монгол улсад орос хэлний сургалтын цар хүрээг өргөжүүлэх зэрэг асуудлуудыг хөндөн ярилцав.
- 09.09-13. Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Гадаад болон хамтын нөхөрлөлийн хэргийн яамны Төрийн сайд, парламентын гишүүн Денис МакШейн Монгол Улсад айлчлав.
- 09.10-12. Монгол, Германы Засгийн газар хоорондын хөгжлийн бодлогын хүрээн дэх хамтын ажиллагааны 2002-2003 оны хэлэлцээ Улаанбаатарт болов. Хэлэлцээний үр дүнд хоёр тал Протоколд гарын үсэг зурав. Протоколын дагуу ХБНГУ-ын Засгийн газар манайд нийтдээ 22 сая еврогийн зээл, тусламж олгохоор тогтов. Хоёр тал 2002-2003 онд “Эдийн засгийн шинэчлэл, зах зээлийн эдийн засаг” болон “Байгаль орчныг хамгаалах, сэргээгдэх эрчим хүч” гэсэн хоёр чиглэлээр хамтран ажиллахаар тохиров.
- 09.10. БНСУ-ын элчин сайд Ким Вон Тэ Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандид Итгэмжлэх жуух бичгээ барив.
- 09.10-20. Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун Нью-Йорк хотод болсон НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 57-р чуулганд оролцов. Чуулганы үеэр тэрээр НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга К.Аннантай уулзаж, 2003 онд Улаанбаатар хотноо зохион байгуулах Ардчиллыг шинээр буюу сэргээн тогтоосон орнуудын 5-р бага хурлын бэлтгэл ажлын талаар мэдээлэл хийж, түүнийг зохион байгуулахад НҮБ-ийн зүгээс идэвхитэй хамтран ажиллаж байгаад талархалаа илэрхийлж, бага хуралд биечлэн оролцохыг урив. Чуулганд оролцохын зэрэгцээ Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун АНУ-д ажлын айлчлал хийж Америкт сурч амьдарч байгаа монгол иргэдэд хууль ёсоор хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тухай асуудлыг урагшлуулах талаар онцлон анхаарч

- үзэхийг хүсэлт болгон манай залууст олгодог засгийн газрыхаа тэтгэлгийн тоо хэмжээг нэмэх асуудлыг судалж үзэхийг санал болгов.
- 09.16. БНСВУ-ын элчин сайд Чан Нгуен Чык Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандид Итгэмжлэх жуух бичгээ барив.
- 09.17. Оманы Султант Улсын элчин сайд Мухаммед Бен Сиад Мухаммед Бен Аль-Аявати Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандид Итгэмжлэх жуух бичгээ барив.
- 09.17-27. Шведийн Олон Улсын хөгжлийн хамтын ажиллагааны агентлагийн (СИДА) төлөөлөгчид Монгол улсад ажлын айлчлал хийв. Төлөөлөгчид Монголд хэрэгжүүлж буй Шведийн Засгийн газрын санхүүжилтээр хэрэгжүүлж буй төслүүдийн явцтай танилцаж цаашид хамтран ажиллах талаар санал солилцов.
- 09.18-20. Тайландын Вант Улсын ГХЯ-ны Зүүн Өмнөд Азийн газрын дарга Норачит Синхасиен тэргүүтэй төлөөлөгчид манайд ажлын айлчлал хийв.
- 09.19. Бүгд Найрамдах Литва Улсын элчин сайд Артурас Жураускас Монгол улсын Ерөнхийлөгч Н.Багабандид Итгэмжлэх жуух бичгээ барив.
- 10.02-05. Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр БНСВУ-ын Ерөнхий сайд Фам Ван Кхай-н урилгаар БНСВУ-д албан ёсны найрсаг айлчлал хийв. Айлчлалын үеэр хоёр тал “Ургамал хамгаалал, хорио цээрийн тухай”, “Гаалийн салбарт хамтран ажиллах тухай” Монгол улс, БНСВУ-ын засгийн газар хоорондын хэлэлцээр, Эрүүл мэндийн салбарт хамтран ажиллах тухай “Монгол, Вьетнамын Эрүүл мэндийн яам хоорондын хэлэлцээр”-т тус тус гарын үсэг зурав.
- 10.06-08. Монгол Улсын Ерөнхий сайд Н. Энхбаяр Бүгд Найрамдах Индонез Улсын Ерөнхийлөгч хатагтай Мегавати Сукарнопутригийн урилгаар БНИндУ-д албан ёсоор айлчлав. Айлчлалын үеэр хоёр тал Дипломат болон албан паспорттой иргэдийг визээс харилцан чөлөөлөх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр, Ургамал хамгаалал, хорио цээрийн салбарт хамтран ажиллах тухай санамж бичиг болон Мал эмнэлэг, хорио цээрийн салбарт хамтран ажиллах тухай Засгийн газар хоорондын санамж бичигт гарын үсэг зурав.
11. 04. Буддын шашны тэргүүн ХИУ Далай лам Данзанжамц сүсэгтэн олны урилгаар манай оронд айлчлав.

- 11.05. Гадаад хэргийн дэд сайд С.Батболд, БНПУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Кшиштоф Денбницки нар “Монгол Улс, Бүгд Найрамдах Польш Улсын хооронд иргэн, гэр бүл, хөдөлмөр, эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх болон эрх зүйн харилцааны тухай гэрээ”-ний Батламж жуух бичгийг солилцох тухай Протоколд гарын үсэг зурав.
- 11.15-19. Монгол Улс БНХАУ-ын хооронд улсын хилийн шугамыг 2 дахь удаагаа хамтран шалгах хамтарсан комиссын гуравдугаар хуралдаан Улаанбаатар хотод болов.
11. 20. Монгол Улс, Европын Холбооны Хамтарсан хорооны 6 дугаар хуралдаан Брюссель хотод болов. Тус хуралдаанаар хоёр тал харилцаа, хамтын ажиллагаагаа эрчимжүүлэхэд цаашид илүү их хүчин чармайлт гарган ажиллахаар шийдвэрлэж, Европын Холбооноос үзүүлж буй тусламжийн хөтөлбөрийг илүү үр ашигтай хэрэгжүүлж ажиллахаа илэрхийлэв.
11. 22. Монгол Улсын цөмийн зэвсггүй статусын тухай Монгол улсын тогтоолыг НҮБ-ын ЕА-н 57 дугаар чуулганаар батлав.
- 11.26-28. Монгол Улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын комиссын үндэсний хэсгүүдийн дарга нарын ээлжит ажлын уулзалт Москва хотод болов. Уулзалтаар ЗГХК-ын X хуралдааны тов, хэлэлцэх асуудлын хүрээг тохирох, комиссын IX хуралдааны шийдвэрийн биелэлтийн явцын тухай мэдээлэл солилцож, хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар арга хэмжээ авах, хоёр орны Засгийн газраас хамтран авах арга хэмжээний хоёр жилийн төлөвлөгөөний төслийг эцэслэх, хоёр улсын хамтарсан “Эрдэнэт” үйлдвэрийн цаашдын эрх зүйн байдлын талаарх хэлэлцээг эхлүүлэх зэрэг асуудлыг авч хэлэлцэв.
- 11.25-30. Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал Канад Улсад ажлын айлчлал хийв. Айлчлалын үеэр Канадын Хүнс, хөдөө аж ахуйн яамтай хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурав.
- 12.02. Монгол Улсаас Норвегийн Вант Улсад суух Элчин сайд С.Онон, Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суух Элчин сайд Т.Баасансүрэн нар тус тус Итгэмжлэх жуух бичгээ барив.
- 12.4-6. Зэвсэг хураах асуудал эрхэлсэн НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч Ж.Данапала манай оронд айлчлав.
- 12.11. “Иргэд, бизнес, төр засаг:Ардчилал, хөгжлийн төлөөх түншлэл” сэдвийн доор Марракеш хотод болсон Засаглалыг

- шинэчлэх асуудлаарх Дэлхийн дөрөвдүгээр чуулга уулзалтад Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун оролцов.
- 12.12. Үйлдвэр худалдааны сайд Ч.Ганзориг, Монгол Улсад БНХАУ-ын хэргийг түр хамаарагч ноён Ванфу Кан нар Хятадын засгийн газраас буцалтгүй тусламж олгох тухай гэрээнд гарын үсэг зурав.
- 12.18. Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандид Арабын нэгдсэн Эмирт Улсаас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Жума Рашид Жасим Рашид Аль-Али Итгэмжлэх жуух бичгээ барив.
- 12.19-21 Болгарын Ардын хурлын дарга Огнян Герджиков Монгол Улсад айлчлал хийв.